

THE BETTER EDUCATION THE BRIGHTER FUTURE



Улаанбаатар Эмпати Сургууль  
**ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ**

**VI АНГИ**

**2024**

- МАТЕМАТИК
- МОНГОЛ ХЭЛ
- IQ

**EDUZONE**  
EDUCATION GROUP

## БИЧГИЙН ШАЛГАЛТЫН ҮЕЭР СУРАГЧДЫН БАРИМТЛАХ ДЭГ

- ✓ Шалгалтын материал нийт 100 онооны 50 асуултаас бүрдэнэ. Асуулт тус бүр 2 оноотой. Үүнд:
  - Математик-30 асуулт
  - Сэтгэн бодох чадвар /IQ/-10 асуулт
  - Монгол хэл-10 асуулт
- ✓ Шалгалтын нийт хугацаа 120 минут байна.
- ✓ Хувилбараа тэмдэглэхээ бүү мартаарай.
- ✓ Хариултын цаасан дээр эрээчиж болохгүй.
- ✓ Хариултаа балын харандаагаар буруу тэмдэглэсэн тохиолдолд баллуурар арилгаж болно.
- ✓ Хариултаа дарсан, тэмдэг тавьсан, зурж балласан тохиолдолд тухайн хариултыг хүчингүйд тооцно.
- ✓ Шалгалт эхлэхээс өмнө хариултын хуудсанд өгөгдсөн сурагчийн мэдээллийг заавал бөглөнө. (овог, нэр, анги, сургууль, хувилбар гэх мэт)
- ✓ Шалгалт эхэлснээс хойш хамгийн эртдээ 60 минутын дараа ангиас гарч болно.
- ✓ Шалгалт эхлэхэд шалгалтын материалыг сайтар шалгана уу.
- ✓ Шаардлагатай тайлбар ба нэмэлт мэдээллүүд шалгалтын материалд өгөгдсөн тул шалгалт эхэлснээс хойш хянагч багшаас асуулт асуухыг хориглоно. Үүнээс гадна сурагчид хоорондоо ярилцах, бие биетэйгээ харандаа, баллуур зэргийг солилцохыг хориглоно.
- ✓ Асуулт тус бүрт нэг зөв хариултыг бөглөнө.
- ✓ Нэмэлт цаас өгөгдөхгүй, бодолтыг шалгалтын материал дээрх хоосон зайд хийж гүйцэтгэнэ.
- ✓ Сурагчдыг нэмэлт цаас, тооны машин, гар утас, толь бичиг ашиглахыг хориглоно.
- ✓ Шалгалтын үеэр гар утас хэрэглэхийг хориглоно. Шалгалт эхлэхээс өмнө гар утастай сурагчид гар утсаа унтраасан байна.
- ✓ Шалгалт эхэлснээс хойш ангиас ямар нэгэн шалтгаан/ариун цэврийн өрөө орох гм/-аар гарахыг хориглоно. Ангиас гарсан сурагчийг ангид дахин оруулахгүй.
- ✓ Бусдаас хуулсан болон хуулуулсан сурагчдын шалгалтын материалыг хүчингүйд тооцно.
- ✓ Шалгалтын дараа шалгалтын материал, хариултын хуудас, бүртгэлийн хуудсыг хурааж авна. Эдгээр материалуудыг хянагч багшид хүлээлгэж өгөөгүй сурагчийн шалгалтын материалыг хүчингүйд тооцно.
- ✓ Бичгийн шалгалтад тэнцсэн сурагчид шалгалтын дараагийн шат буюу ярилцлагад орох эрхтэй болно.

## МОНГОЛ ХЭЛ

### Эрх ишигний үлгэр

Жигтэйхэн зөрүүд зантай эрх ишиг байжээ. Эх нь: -Үр минь, ишиг минь нохой руу ойртож болохгүй шүү гэж захиж гэнэ. Гэтэл хөх ишиг уяатай нохой руу очив гэнэ. Банхар нохой унтаж байлаа. Ишиг нохойн толгой руу мөргөөд авч гэнэ.

Нохой аймшигтайгаар архиран өндийж гэнэ. Ишиг майлан зугтаж гэнэ. Эх нь ишгээ үнэрлэн, -Үр минь, ишиг минь ээжийнхээ үгэнд орохгүй бол ингэдэг юм шүү дээ. Хурц эвэртэй эр ямааны уурыг битгий хүргээрэй гэж захиж гэнэ. Хөх ишиг эхийнхээ үгэнд орсонгүй.

Хотын захад хэвтэж байсан эр ямааны нуруун дээр дэвхрэн гарчээ. Гэтэл эр ямаа уурлан босож, ишгийг унатал мөргөв. Эх нь ишгээ үнэрлэн, -Үр минь, ишиг минь, ээжийнхээ үгэнд орохгүй бол ингэдэг юм шүү дээ. Орой үдшийн цагт хотноос хол битгий тоглоорой. Чоно иднэ шүү гэж захиж гэнэ. Эрх хөх ишиг эхийнхээ үгэнд оролгүй хотны захаар **тонгочин давхив**. Бүрэнхий харанхуйгаар чоно дайрч гэнэ. Гэтэл нохой хуцаж эзэн нь буудав. Эрх хөх ишиг их айж, үүнээс хойш эхийнхээ үгэнд ордог болж гэнэ.

1. Эхэд ишигний зөрүүд зан түүнийг юунд хүргэсэн бэ?

- A) Нохой дайрах
- B) Эр ямаанд мөргүүлэх
- C) Чоно хот руу дайрах
- D) Бүгд зөв

2. “Нохой аймшигтайгаар архиран өндийсэн” шалтгаан юу вэ?

- A) Хөх ишиг эхийнхээ үгэнд ороогүй учраас
- B) Бүрэнхий харанхуйгаар чоно хот руу дайрсан учраас
- C) Эрх хөх ишиг хотны захаар тонгочин давхисан учраас
- D) Ишиг нохойн толгой руу мөргөөд авсан учраас

3. Энэхүү эхэд юуны тухай өгүүлсэн бэ? Зөв илэрхийлсэн хэлц үгийг сонгоорой.

- A) Зүрх хүрэхгүй
- B) Дөргүй бух шиг
- C) Гууль нь цухуйх
- D) Долоон голтой

4. Эхэд байгаа “зөрүүд” хэмээх үгийн ойролцоо утгатай үгийг олоорой.

- A) нялхамсуу
- B) хэрсүү
- C) гөжүүд
- D) чих зөөлөн

5. Эхийн үйл явдлыг дэс дараагаар нь зөв байрлуулсныг олоорой.

1. Эхийнхээ үгэнд ордог болжээ.
2. Жигтэйхэн зөрүүд зантай эрх ишиг байжээ.
3. Эрх ишиг хотны захаар тонгочин давхив.
4. Эрх ишиг Банхар нохойн толгой руу мөргөв.
5. Эр ямааны нуруун дээр дэвхрэн гарчээ.
6. Чоно дайрч, эзэн нь буудав.

- A) 2,5,4,3,6,1
- B) 2,4,5,3,6,1
- C) 1,2,3,4,6,5
- D) 4,2,3,1,5,6

6. “Харанхуйгаар” хэмээх үгийг үеэр зөв задалсан хэсгийг дугуйлаарай.

- A) хар-ан-хуй-гаар
- B) ха-ранх-уй -гаар
- C) ха-ран-хуй-гаар
- D) хар-ан-хуйг-аар

7. Хэлний үгийн “Н” гийгүүлэгчийг бичигт яаж тэмдэглэдэг вэ?

- A) Өмнө нь эгшиггүй бичнэ.
- B) Ард нь эгшиггүй бичнэ.
- C) Ард нь эгшигтэй бичнэ.
- D) Өмнө нь эгшигтэй бичнэ.

8. Хоолойн “Г”-тэй үгийг олж тэмдэглэнэ үү.

- A) аймгаас
- B) нутгийн
- C) багийн
- D) багын

9. “Тонгочин” гэдэг үг эхэд ямар утгаар орсон байна вэ? Тохирох утгыг олоорой.

- A) гүйх
- B) түргэн тонгорон хөдлөх
- C) дэгдэх
- D) дэвцэх

10. Урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад бусдаасаа өөр бичигдэх үг аль нь вэ?

- A) үзвэр+ээр
- B) олсон+оос
- C) бичиг+ийг
- D) улирал+ын

## МАТЕМАТИК

11.  $2\frac{3}{4} \cdot \frac{2}{3} = \frac{A}{B}$  бол А+ В-ийн нийлбэр дараах хариултаас аль нь вэ?

- A) 16      B) 17      C) 18      D) 19

12. CCXLI ром тоог араб тоогоор илэрхийлсэн хариуг олоорой.

- A) 251      B) 241      C) 216      D) 256

13.  $A = \{1, 3, 7, 17, 27\}$   $B = \{0, 1, 4, 7, 10, 17\}$  олонлогуудын огтлолцол аль нь вэ?

- A)  $C = \{0, 1, 3, 4, 7, 10, 17, 27\}$       B)  $C = \{0, 3, 4, 10, 27\}$   
 C)  $C = \{1, 7, 17\}$       D)  $C = \{3, 27\}$

14. 58 ба 140 тоонуудын хамгийн бага ерөнхий хуваагдагчийг ол.

- A) 4060      B) 2      C) 4      D) 2030

15. 24.57м урттай төмөр утсыг 2:3:4 харьцаатай гурван хэсэгт яаж хуваах вэ?

- A) 5.46м, 8,19м, 10,92м  
 B) 5.406м, 8,159м, 1,92м  
 C) 5.4м, 8,9м, 10,92м  
 D) 0.46м, 8,19м, 15,92м

16. Дараах өгүүлбэрүүдийн аль нь үнэн бэ?

- A) Хамгийн бага анхны тоо бол 1.  
 B) Хоёр анхны тооны нийлбэр нь үргэлж тэгш тоо байна.  
 C) Хамгийн бага хоёр оронтой анхны тоо бол 13.  
 D) Анхны тоо бүр 2 натурал хуваагчтай.

17. Гурван тооны нийлбэр 9000. Нэг нь 1452, нөгөө тоо нь үүнээс 3 дахин бага байв. Гурав дахь тоог олоорой.

- A) 4356      B) 1740      C) 4644      D) 3192

18. Барааны үнэ 100% нэмэгдээд дараа нь 40%-иар буурсан бол анхны үнээсээ хэдэн хувиар нэмэгдэх вэ?

- A) 80%      B) 60%      C) 40%      D) 20%

19. 2,0,3,5 цифрүүдийг ашиглан цифр давтагдахгүй дөрвөн оронтой тоо хэдийг зохиож болох вэ?

- A) 24      B) 18      C) 4      D) 256

20. 25. 607 аравтын бутархай тоог зөв задалсан хариуг олоорой.

- A)  $2 \cdot 10 + 5 \cdot 1 + 6 \cdot \frac{1}{100} + 7 \cdot \frac{1}{100}$   
 B)  $2 \cdot 1 + 5 \cdot \frac{1}{10} + 6 \cdot \frac{1}{100} + 7 \cdot \frac{1}{1000}$   
 C)  $2 \cdot 10 + 5 \cdot 1 + 6 \cdot \frac{1}{10} + 7 \cdot \frac{1}{1000}$   
 D)  $2 \cdot 10 + 5 \cdot 1 + 6 \cdot \frac{1}{100} + 7 \cdot \frac{1}{1000}$

21. Дараах тоонуудаас хамгийн ихийг нь ол.

- A)  $\frac{8}{12}$     B)  $\frac{3}{12}$     C)  $\frac{11}{12}$     D)  $\frac{1}{12}$

22. Ямар тоог 8-д хуваахад 405ногдож, 7 үлдэх вэ?

- A) 3607    B) 3638    C) 3247    D) 2843

23. Үл мэдэгдэгчийг олоорой.


$$\frac{83}{60} - a = \frac{100}{60} - \frac{48}{60}$$

- A) 31    B) 2    C)  $\frac{135}{60}$     D)  $\frac{31}{60}$

24. 2-т хуваагддаг, 4-д хуваагддаггүй хамгийн бага 3 оронтой тоог олоорой.

- A) 100    B) 102    C) 104    D) 106

25. Гурван параллелепипедийн гадаргуугийн талбай тэнцүү бол мэдэгдэхгүй байгаа  $a$ ,  $c$  ирмэгүүдийн нийлбэрийн уртыг олоорой.



- A) 22    B)  $22\frac{1}{3}$     C)  $22\frac{2}{3}$     D)  $23\frac{1}{3}$

26.  $1.3 - \frac{35}{72} : (5\frac{1}{12} - 3\frac{5}{8}) = ?$

- A) 1    B)  $\frac{29}{30}$     C)  $\frac{14}{15}$     D)  $\frac{49}{30}$


27. Адил хажуут гурвалжны оройн өнцөг  $40^\circ$  бол суурийн өнцгийг олоорой.

- A)  $40^\circ$     B)  $50^\circ$     C)  $60^\circ$     D)  $70^\circ$

28. 225 тоог анхны тоон үржигдэхүүнд задал.

- A)  $9 \cdot 25$     B)  $3^2 \cdot 25$     C)  $9 \cdot 5^2$     D)  $3^2 \cdot 5^2$

29. Дараах дүрс тэгш хэмийн хэдэн тэнхлэгтэй вэ? /Зөв зургаан өнцөгт/




- A) 3    B) 6    C) 9    D) 12

30. Гурвалжны гадаад өнцгүүдийн харьцаа 3:4:5 бол хамгийн их дотоод өнцгийн хэмжээг олоорой.

- A)  $30^\circ$     B)  $60^\circ$     C)  $90^\circ$     D)  $100^\circ$

31. 120 см-ийн тавиур дээр 2 см-ийн зузаантай ижил хайрцгийг хооронд нь зай завсаргүйгээр байрлуулахад  $(2a - 4)$  см зай үлдэнэ. Тэгвэл  $a = 12$  бол тавиур дээр хэдэн хайрцаг байрлуулсан бэ?



- A) 48    B) 50    C) 54    D) 58

32.  $(15 - 13.7) \cdot 8.8 + (14 - 12.725) \cdot 12.1 = ?$  үйлдлийг гүйцэтгэ.

- A) 24.8675    B) 25.86    C) 26.8675    D) 27.75


33. Гүдгэр 6 өнцөгтийн дотоод өнцгийн нийлбэр хэд вэ?

- A)  $1080^\circ$     B)  $540^\circ$     C)  $720^\circ$     D)  $1440^\circ$

34.  $\left(1 - \frac{1}{2}\right) \cdot \left(1 - \frac{1}{3}\right) \cdot \left(1 - \frac{1}{4}\right) \cdot \dots \cdot \left(1 - \frac{1}{21}\right) \cdot \left(1 - \frac{1}{22}\right) = ?$


- A)  $\frac{1}{2}$     B)  $\frac{1}{10}$     C)  $\frac{1}{22}$     D)  $\frac{1}{2 \cdot 3 \cdot 4 \cdot \dots \cdot 22}$

35. Батын гэрээс сургууль хүртэл явдаг автобусны маршрутыг харуулсан бол аль маршрут нь ойр вэ?




- A) Г - А - В - D - E    B) Г - А - В - C - E  
C) Г - А - C - E    D) Г - А - C - D - E

36.  $a$  см урттай утасны хоёр талаас харгалзан 2 см, 1 см-ыг тастаж үлдсэн хэсгээр нь квадрат хийсэн бол квадратын талын уртыг  $a$ -аар илэрхийл.




- A)  $\frac{a}{4} - \frac{3}{4}$     B)  $\frac{a}{4} - 3$     C)  $\frac{a+3}{4}$     D)  $\frac{a}{4} + 3$

37. Дараах зурганд хэчнээн ялгаатай өнцөг тэмдэглэх боломжтой вэ?



- A) 10    B) 13    C) 15    D) 31

38. Дараах зургаар А хотоос В хот руу, В хотоос С хот руу очих замуудыг үзүүлсэн бол А хотоос В хотыг дайраад С хотод хүрээд буцаад В хотоор дайраад А хотод ирэхдээ нэг явсан замаараа явахгүйгээр хэдэн ялгаатай замаар очоод ирэх вэ?



- A) 14    B) 144    C) 72    D) 49

39. 1-ээс 2024 хүртэлх тоог нэг эгнээнд залгаж бичсэн бол урдаасаа 2025 дахь дугаарт хэдийн цифр байрлах вэ? (12345678910111213141516... гэх мэт байрлуулна)

- A) 1    B) 2    C) 4    D) 7

40. Цифрүүдийн үржвэр нь 36 байх 5 оронтой тоо хэд байх вэ?

- A) 1    B) 120    C) 30    D) 40

**IQ**

41. Үсгүүдийн байрыг сольж үг бүтээгээд илүүц нэрийг сонго.  
 А) ХОНОР В) АДРАНХ С) СУВ Д) ЛИЙГӨ

42. Асуултын тэмдгийн оронд тохирох тоог ол.

I. II.

<table border="0"> <tr><td>□</td><td>◇</td><td>*</td><td>●</td></tr> <tr><td>*</td><td>△</td><td>●</td><td>○</td></tr> <tr><td>◇</td><td>△</td><td>○</td><td>□</td></tr> <tr><td>●</td><td>□</td><td>○</td><td>◇</td></tr> <tr><td>△</td><td>*</td><td>◇</td><td>○</td></tr> </table>	□	◇	*	●	*	△	●	○	◇	△	○	□	●	□	○	◇	△	*	◇	○	<table border="0"> <tr><td>6437</td><td>1345</td><td>4657</td></tr> <tr><td>3671</td><td>5173</td><td></td></tr> </table>	6437	1345	4657	3671	5173	
□	◇	*	●																								
*	△	●	○																								
◇	△	○	□																								
●	□	○	◇																								
△	*	◇	○																								
6437	1345	4657																									
3671	5173																										


◇ △ ○ □ = ?

- A) 1345 B) 4657 C) 5173 D) 3671

43. 4 охинтой айлын нэг нь ном уншиж байхад, нэг нь зураг зурж байсан ба нэг нь шатар тоглож байсан бол 4дахь охин юу хийж байсан вэ ?

- A) ном уншиж B) зураг зурж  
 C) шатар тоглож D) хоол хийж

44. Асуултын тэмдгийн оронд ямар дүрс байх вэ?



- A) B) C) D)

45. Асуултын тэмдгийн оронд ямар тоо байх вэ?

3	4
2	14

5	2
3	13


2	7
6	?

- A) 2 B) 6 C) 18 D) 20

46. Ууганд 20 улаан, 30 хөх, 20цагаан бөмбөг байв. Түүнээс харалгүй таамгаар (нэг удаа нэг бөмбөг авна) нэг өнгийн 20 бөмбөг авахын тулд хамгийн багадаа хэдэн бөмбөг авах вэ?


- A) 19 B) 58 C) 60 D) 70

47. Хамгийн эхэнд аль аяга дүүрэх вэ?




- A) 9 B) 5 C) 7 D) 4

48. Дараах зурагт нийт хэдэн ширхэг куб байгааг олоорой.



- A) 86 B) 87 C) 88 D) 89

49. I дүрсийг таглавал II дүрсэн дэх пирамид үүснэ. Тэгвэл II дүрсэн дэх x, y-ийг ол.



- $\frac{X}{Y}$
- A) 1/3 B) 1/6 C) 2/2 D) 2/6

50. 1;10; 3; 9; 5; 8; 7; 7; 9; 6; ?; ?

- A) 11; 5 B) 10; 5 C) 10; 4 D) 11; 6



**EDUZONE**  
EDUCATION GROUP



### Улаанбаатар Эмпати Сургууль

- ✉ info.ub@empathy.edu.mn ☎ +976 1146 2610
- 📍 Монгол улс, Улаанбаатар хот 13260, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Амгалангийн гудамж



### Дархан Эмпати Сургууль

- ✉ info.darkhan@empathy.edu.mn ☎ +976 7037 5757
- 📍 Монгол улс, Дархан-Уул аймаг, Дархан 45040, Өргөө баг, 21-р дүүрэг



### Орхон Эмпати Сургууль

- ✉ info.orkhon@empathy.edu.mn ☎ +976 7035 2792
- 📍 Монгол улс, Орхон аймаг, Эрдэнэт 61020, Баян-Өндөр сум, Отгонбилэгийн гудамж



### Баян-Өлгий Эмпати Сургууль

- ✉ info.bu@empathy.edu.mn ☎ +976 7042 2608
- 📍 Монгол улс, Баян-Өлгий аймаг 83139, Өлгий, 13-р дүүрэг

## САНАМЖ

Тус шалгалтын материал нь Эмпати сургуулиудын өмч ба та хэрэв тус шалгалтын материалыг олсон бол Эмпати сургуулиудад буцааж өгнө үү. Тус шалгалтын материалд байгаа аливаа дасгал бодлогыг хуулбарлаж, олшруулахыг хориглоно.